



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/382

Булган сум

“Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажиллах, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолын хавсралт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигын эрсдэлээс ангид байх, авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх видео контент бүтээж, “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажилласугай.

2. Видео контент бүтээхэд шаардагдах 1,250,000 (нэг сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал”-аас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

3. Удирдлага зохион байгуулалтаар хангаж, тайланг зохих журмын дагуу гаргаж, санхүүтэй тооцоо хийхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

